



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 2.11, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах” нийцлийн аудитын /ГНАГ-2024/06-ШТА-НА/ тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Сонгуулийн хорооны дарга (Л.Хосбаяр)-т зөвлөсүгэй.

3.Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4.Тайланг Үндэсний аудитын газар болон Нийслэл, дүүргийн сонгуулийн хороо-нд тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ





НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ,
ДҮГНЭЛТ ГАРГАХ



УЛААНБААТАР ХОТ

2024 ОН

2024 ОН	
Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг 2
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Хүснэгтийн жагсаалт 3
Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс	Хавсралтын жагсаалт
Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл 4
 Э.Мөнхмандах	1.1 УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх? 5
Аудитын менежер:	1.1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон уу? 6
 Л.Саранбаатар	1.1.2 Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан уу? 6-7
Ахлах аудитор:	1.1.3 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн үү? 7
 Ж.Жавзанпагма	1.2 УИХ-ын сонгууль зохион байгуулах улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх? 8
Аудитор:  Н.Чулуун-эрдэнэ	1.2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан? 8-9
 М.Номин-эрдэнэ	1.2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан уу? 9-10
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 327787	1.2.3 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн үү? 10
Тайланг НТАГ-ын http://audit.mn/ веб сайтаас үзнэ үү.	Аудитын дүгнэлт 11
	Аудитын зөвлөмж 12
	Холбогдох байгууллагын санал 13
	Хавсралтууд 14

Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
МУИХСТХ	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
НАНБХАСЗАСЗУСТ Х	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
УИХ	Улсын Их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
УБЕГ	Улсын Бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий газар
НУБГ	Нийслэлийн Улсын бүртгэлийн газар
НЦУГ	Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар
НСХ	Нийслэлийн сонгуулийн хороо
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ХУД	Хан-уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
НД	Налайх дүүрэг
МТБ	Мэдээлэл технологийн баг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Нийслэлийн сонгуулийн хороонд санхүүжилт олгосон хуваарь	6
Хүснэгт 2	Сонгуулийн хороодод төсөв хуваарилсан байдал	7
Хүснэгт 3	Улсын төсвөөс Нийслэл, дүүргийн сонгуулийн хороодод олгосон санхүүжилт	8
Хүснэгт 4	Улсын төсвөөс НУБГ, НЦУГ-т олгосон санхүүжилт	9
Хүснэгт 5	НСХ-ны сонгуулийн зардлын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан	9-10

Дугаар	Хавсралтын жагсаалт Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Аудитаар илэрсэн алдаа, зөрчил	16

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн аудитыг гүйцэтгэв.

Аудитын зорилт

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Нийслэл, дүүргийн сонгуулийн хороо, Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газрыг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817-6:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийн, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай
- Холбогдох бусад эрх зүйн акт

Аудит хийх хугацаа:

Аудитыг 2024 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

БҮЛЭГ 1.1 УИХ-ЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН ЭСЭХ

Ерөнхий мэдээлэл.

СЕХ-ны 2024 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах НСХ-г 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

НСХ нь МУИХСТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу сонгууль зохион байгуулах дүүргийн сонгуулийн хороог НСХ-ны 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 2 дугаар тогтоолоор тус бүр 7 хүний бүрэлдэхүүнтэй байхаар баталжээ.

Нийслэлийн хэмжээнд Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг 10 сонгуулийн хороо, 513 хэсгийн хороодтойгоор зохион байгуулж, сонгуулийн хорооны гишүүн 72, хэсгийн хорооны гишүүн 4497, санхүү, бичиг хэргийн ажилтан 20, МТ-ийн даамал 564, МТГ-ийн гишүүн 41 нийт 5194 албан хаагчтайгаар сонгуулийн үйл ажиллагааг явуулсан байна.

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Сонгуулийн Ерөнхий хорооны төсөвт УИХ-ын сонгуульд зориулан 32,180,300.0 мянган төгрөг, Засгийн газрын 2024 оны 200 дугаар тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас сонгууль зохион байгуулахад шаардагдах нэмэлт санхүүжилт 8,825,530.4 мянган төгрөг нийт 41,005,830.4 мянган төгрөг баталснаас Нийслэлд 4,368,846.0 мянган төгрөг буюу нийт төсвийн 10.65%-ийг хуваарилж, зарцуулсан байна.

Мөн УБЕГ-ын төсөвт 3,039,033.8 мянган төгрөг баталснаас НУБГ-т 668,159.4 мянган төгрөг буюу 21.9%, ЦЕГ-ын төсөвт 1,460,075.33 мянган төгрөг баталснаас 15,942.0 мянган төгрөгийг буюу 1.09%-ийг НЦУГ-т хуваарилж, зарцуулсан байна.

1.1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон уу?

СЕХ-ны Тамгын газраас НСХ-нд 2024 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хооронд 5 удаагийн албан бичгээр НСХ-ны төсвийг санхүүжилтийн хуваарь, тайлбарын хамт хүргүүлжээ. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-1. НСХ-нд санхүүжилт олгосон хуваарь

№	Санхүүжилт хуваарилсан байгууллага	Албан бичгийн огноо, дугаар	Өссөн дүнгээр /төгрөг/	
			Хуваарилсан зардлын ангиллын тоо	Нийт төсөв
1	СЕХ-ны Тамгын газар	2024.04.16 №3/229	2	5,535.0
2	СЕХ-ны Тамгын газар	2024.05.02 №3/290	6	384,170.0
3	СЕХ-ны Тамгын газар	2024.05.21 №3/373	8	619,400.0
4	СЕХ-ны Тамгын газар	2024.06.09 №3/472	10	668,840.0
5	СЕХ-ны Тамгын газар	2024.06.18 №3/562	16	4,137,420.0
6	СЕХ-ны Тамгын газар	2024.06.30 А/45	16	4,368,846.0

СЕХ 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/45 дугаар тушаалаар эдийн засгийн 16 ангиллаар 4,368,846.0 мянган төгрөг баталжээ.

Төсөв батлахдаа нийслэлд хуваарилсан төсөв дээр 231,426.0 мянган төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг нэмж баталсан байна.

Хуваарилсан төсвөөс 4,356,971.2 мянган төгрөг буюу 99.73%-ийг зарцуулж, 11,874.8 мянган төгрөг буюу 0.27%-ийг буцаан төвлөрүүлсэн байна.

Дүгнэлт: Улсын төсвөөс олгосон хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцож хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн нь байна.

1.1.2 Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан уу?

НСХ нь дүүргийн сонгуулийн хорооны төсвийн хуваарийг “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих тухай журам”-ын 2.1¹-д заасны дагуу нийт сонгогчдын тоо болон хэсгийн хороодын эзлэх хувь, сонгуулийн болон хэсгийн хороодод ажиллах ажилтны тоонд үндэслэн хуваарилахаар заасан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-2. Сонгуулийн хороодод төсөв хуваарилсан байдал

	/Мян.төг/
--	-----------

¹ 2.1. Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчдын тоо, сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна.

№	Харъяалах СХ-ны нэр	Хэсгийн хорооны тоо	Эзлэх хувь /%/	Сонгуулийн насны иргэдийн тоо	Эзлэх хувь /%/	Батлагдсан төсөв	Эзлэх хувь /%/
1	НСХ	-		-		74,844.0	1.7
2	БГД СХ	81	15.8	145,838.0	13.9	707,774.0	16.2
3	БЗД СХ	124	24.2	243,918.0	23.3	1,065,876.0	24.4
4	БНД СХ	11	2.1	26,468.0	2.5	83,776.0	1.9
5	БХД СХ	2	0.4	2,770.0	0.3	27,072.0	0.6
6	НД СХ	14	2.7	26,468.0	2.5	121,668.0	2.8
7	СБД СХ	49	9.6	131,442.0	12.6	387,394.0	8.9
8	СХД СХ	108	21.1	219,313.0	21.0	866,270.0	19.8
9	ХУД СХ	74	14.4	153,077.0	14.6	624,746.0	14.3
10	ЧД СХ	50	9.7	96,377.0	9.2	409,426.0	9.4
	НИЙТ ДҮН	513	100.0	1,045,671.0	100.0	4,368,846.0	100.0

Нийслэлийн хэмжээнд 10 сонгуулийн хороо, 513 хэсгийн хороонд 5194 албан хаагч ажиллах, 1,045,671.0 сая иргэн санал өгөхөөр урьдчилсан байдлаар тооцоолсон байна.

Хуваарилсан 4,368,846.0 мянган төгрөгийг дүүргийн нийт сонгогчдын тоо болон хэсгийн хороодын эзлэх хувь, сонгуулийн болон хэсгийн хороодод ажиллах ажилтны тоонд харьцуулан үзвэл үндэслэлтэй байна.

Дүгнэлт: Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

БҮЛЭГ 1.2 УИХ-ЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН ЭСЭХ

1.2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?

Нийслэл, дүүргийн сонгуулийн хороод УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс олгосон 4,368,846.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 4,356,971.2 мянган төгрөг буюу нийт олгосон санхүүжилтийн 99.73%-ийг зарцуулж, үлдэгдэл 11,874.8 мянган төгрөг буюу 0.27%-ийг СЕХ-ны Төв төрийн сангийн 100900022001 тоот дансанд буцаан төвлөрүүлжээ.

Хүснэгт-3. Улсын төсвөөс Нийслэл, дүүргийн сонгуулийн хороодод олгосон санхүүжилт

санхүүжилт				/мян.төг/
№	Харьяалах СХ-ны нэр	Батлагдсан төсөв	Зардлын гүйцэтгэл	Үлдэгдэл
1	НСХ	74,844.0	74,844.0	-
2	БГД СХ	707,774.0	707,774.0	-
3	БЗД СХ	1,065,876.0	1,061,733.5	4,142.5
4	БНД СХ	83,776.0	83,776.0	-
5	БХД СХ	27,072.0	27,072.0	-
6	НД СХ	121,668.0	121,668.0	-
7	СБД СХ	387,394.0	383,621.0	3,773.0
8	СХД СХД	866,270.0	864,514.6	1,755.4
9	ХУД СХ	624,746.0	623,228.1	1,517.9
10	ЧД СХ	409,426.0	408,740.0	686.0
	НИЙТ ДҮН	4,368,846.0	4,356,971.2	11,874.8

Нийслэл, дүүргийн сонгуулийн хороодын зардлын зарцуулалтын холбогдох баримт материалыг шалгахад нийт 38,767.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. *Хавсралт 1. Үүнд:*

- БЗД, НД, СБД, СХД-ийн сонгуулийн хороод анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 32,070.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн;
- БГД, БЗД, БНД, НД, СБД-ийн сонгуулийн хороод 2,904.0 мянган төгрөгийн болзошгүй зардлыг зориулалт бусаар зарцуулсан;
- БНД, СБД, СХД-д хуваарилсан зардлаас 4,345.1 мянган төгрөгийг зохих зөвшөөрөлгүйгээр зардлын ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан байна.

Эдгээр нь НББТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.7², 20 дугаар зүйлийн 20.1.4³, СЕХ-ны 2021 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.8⁴, 4 дүгээр зүйлийн 4.1⁵ дэх заалтыг зөрчжээ.

² 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”

³ 20.1.4. “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;”

⁴ 3.8 Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

⁵ 4.1. “Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө.”

НУБГ, НЦУГ-ын байгууллагуудын хувьд:

УИХ-ын сонгуулийн зардалд НУБГ-т 668,159.4 мянга, НЦУГ-т 15,942.0 мянган төгрөгийн санхүүжилтийг дээд шатны байгууллагуудаас олгожээ. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-4. Улсын төсвөөс НУБГ, НЦУГ-т олгосон санхүүжилт

№	Байгууллагын нэр	Олгосон санхүүжилт	Гүйцэтгэл	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	/мян.төг/
1	НУБГ	668,159.4	668,159.4	-	
2	НЦУГ	15,942.0	15,942.0	-	
	НИЙТ ДҮН	684,101.4	684,101.4	-	

УБЕГ-аас НУБГ-ын сонгуулийн үйл ажиллагаанд 668,159.4 мянган төгрөгийг сургалт, урамшуулал, бичиг хэрэг, тээвэр шатахуун, унаа, томилолтын зардалд, ЦЕГ-аас НЦУГ-т 15,942.0 мөнгөн төгрөгийг алба хаагчдын хоол, унаа, бичиг хэргийн зардалд зарцуулахаар хуваарилсныг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна.

Дүгнэлт: Баянгол, Баянзүрх, Багануур, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн сонгуулийн хороод батлагдсан төсвийг зориулалт бус, арвилан хэмнэлтгүй, анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна.

1.2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан уу?

МУИХСТХ-ийн 10 дугаар зүйл, СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих тухай журам”-ын дагуу Нийслэл, дүүргийн СХ-ны төсвийн гүйцэтгэлийн тайлагналыг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт-5. НСХ-ны сонгуулийн зардлын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан

№	Зардлын ангилал	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл төсөв	/мян.төг/
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	500.0	497.5	2.5	
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	6,807.0	6,807.0	-	
3	Мэдээлэл технологийн баг, даамлын сургалт	12,112.0	12,092.0	20.0	
4	Нийслэл, дүүрэг, хэсгийн хороодын бичиг хэрэг	64,360.0	64,333.4	26.5	
5	Нийслэл, дүүрэг, хэсгийн хороодын шуудан холбоо	79,300.0	78,181.6	1,118.3	
6	Нийслэл, дүүрэг, хэсгийн хороодын унааны зардал	221,690.0	221,060.0	630.0	
7	Санал авах байр бэлтгэх зардал	346,500.0	343,495.2	3,004.7	
8	Сурталчилгааны зардал	75,601.0	75,600.3	0.6	
9	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийн авах хүлээлгэн өгөх зардал	38,520.0	38,020.0	500.0	
10	МТБ-ийн мэдээ дамжуулах, унааны зардал	10,920.0	10,970.0	(50.0)	
11	Нийслэл, дүүрэг, хэсгийн хороодын гишүүдийн урамшуулал, НДШ	2,867,480.0	2,863,707.0	3,773.0	
12	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	372,680.0	370,821.0	1,859.0	
13	Нийслэл, дүүрэг, хэсгийн хороодын гишүүдийн хоолны зардал	263,000.0	262,950.0	50.0	

14	ДСХ-оос НСХ-нд сонгуулийн дүн, баримт бичиг хүлээлгэн өгөх томилолтын зардал	420.0	260.0	160.0
15	МТБ-ийн шуурхай ажиллагааны унааны зардал	2,800.0	2,330.0	470.0
16	Болзошгүй зардал	6,156.0	5,846.0	310.0
НИЙТ ДҮН		4,368,846.0	4,356,971.2	11,874.8

Нийслэлийн хэмжээнд УИХ-ын сонгуулийн зардалд 16 төрлөөр нийт 4,356,971.21 мянган төгрөг буюу хуваарилсан төсвийн 99.7%-ийг зарцуулж, 11,874.8 мянган төгрөг буюу 0.27%-ийг зарцуулаагүй буцаан төвлөрүүлсэн байдлаар тайлагнажээ.

Дүүргийн сонгуулийн хороо СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.4-д заасны дагуу сонгуулийн зардлын зарцуулалтын тайланг хугацаанд нь гаргаж тайлагнаагүй байна.

Энэ нь СЕХ-ноос сонгууль дууссаны дараа төсөв, баталж, нэмэлт санхүүжилт олгосноос шалтгаалж хугацаандаа тайлагнах боломжгүйд хүрсэн байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн сонгуулийн хороо зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан ч СЕХ-ноос сонгууль дууссаны дараа төсвийн хуваарь хийснээс шалтгаалж хугацаа хоцроосон байна.

1.2.3 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн үү?

МУИХСТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.2.5⁶-д заасны дагуу НСХ-ноос дүүргийн сонгуулийн хороодод хуваарилсан сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

Аудитын баримтад авагдсан нотлох зүйл болон Нийслэл, дүүргийн СХ-ны нягтлан бодогч нартай ярилцлага хийж тодруулга авахад Нийслэлийн СХ-ноос дүүргийн СХ-ны сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Шалтгаан нөхцөлийг тодруулахад СЕХ-ноос НСХ-ны зардлын төлөвлөгөөг нэгдсэн журмаар батлаагүй, санал аваагүй, зардлыг хэсэгчлэн хуваарилж, сүүлийн санхүүжилтийг УИХ-ын сонгуулийн үйл ажиллагаа дууссаны дараа баталгаажуулан ирүүлснээс шалтгаалан цаг хугацааны хувьд хяналт шалгалт хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн байна.

Дүгнэлт: Нийслэлийн сонгуулийн хорооноос дүүргийн сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

⁶ 16.2.5. “Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороодод хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;”

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Нийслэлийн хэмжээнд Улсын Их хурлын сонгуулийн зардалд нийт 4,356,971.21 мянган төгрөг буюу хуваарилсан төсвийн 99.7%-ийг зарцуулснаас 38,767.1 мянган төгрөг буюу 0.9%-ийг зарцуулахдаа холбогдох хууль, журмыг зөрчсөн байна.
2. Баянгол, Баянзүрх, Багануур, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн сонгуулийн хороод батлагдсан төсвийг зориулалт бус, арвилан хэмнэлтгүй, анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна.
3. Нийслэл, дүүргийн сонгуулийн хороо зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан ч СЕХ-ноос сонгууль дууссаны дараа төсвийн хуваарь хийснээс шалтгаалж зардлын тайлагнал хугацаа хоцорч, гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэлийн сонгуулийн хороонд:

1. Алдаа зөрчил гаргасан сонгуулийн болон хэсгийн хороодын ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах;
2. Нийслэлийн сонгуулийн хороо нь дүүргийн сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлж холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ

Нийслэлийн сонгуулийн хорооноос ирүүлсэн саналыг хүлээн авч тайланд холбогдох засвар хийв. Дүүргийн сонгуулийн хорооноос холбогдох саналгүй байна.


НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРОО
Улаанбаатар хот, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160,
Утас: (076) 7010 127-1

НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2024.08.14 № 38
Төсөл: 2024.08.09 -ийн № 1134

Тайлбар хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийх 2024 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 1134 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах" тайлантай танилцлаа.

Нийслэлийн сонгуулийн хороонд холбогдох дараах хоёр дүгнэлт, аудитын зөвлөмжид хариу тайлбар, саналыг үүгээр хүргүүлж байна. Үүнд:

1. Тайлангийн төслийн 1.2.2-ын дүгнэлт хэсэгт "Нийслэл, дүүргийн сонгуулийн хороо зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан ч хугацаа хоёрдооноос байна" гэжээ.

Тайлбар: Сонгуулийн хорооны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 4.4-д "сум, дүүргийн сонгуулийн хорооны нэгтгэл бодогч нар 4.3-т заасан тайланг өгнө", нийслэлийн сонгуулийн хороонд сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 3 хоногт хүлээлгэж өгнө" гэж заасан нь 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр буюу баасан гаригт санал хураалт явагдаж, дараагийн 3 хоногийн 2 өдөр нь амралтын өдөр байсан, мөн Сонгуулийн ерөнхий хорооноос 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр сүүлийн санхүүжилтийг олгосон ба уг санхүүжилтийн гүйцэтгэл хийх боломжтой ажлын эхний өдөр нь 07 дугаар сарын 01-ний өдөр байгаа тул дүүргийн сонгуулийн хороод зардлын гүйцэтгэл бүрэн хийж, санхүүгийн тайлан гарган, нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлж цаг хугацааны хувьд боломжгүй байсан тул дээрх дүгнэлттэй санал нийлэхгүй байна.

2. Тайлангийн төслийн 1.2.3-ын дүгнэлт хэсэгт "Нийслэлийн сонгуулийн хорооноос дүүргийн сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлэггүй байна" гэжээ.

Тайлбар: Нийслэлийн сонгуулийн хороо нь дүүргийн сонгуулийн хороо бол н хэсгийн хороо, сонгогчдын тоо, дүүрэг хэсгийн хороодын гишүүд, даамал, мэдээлэл технологийн ажилтны тоо судалгаанд үндэслэн санхүүжилтийн дүнг тооцон хуваарилж, холбогдох шийдвэр гарган, албан бичгээр зардлын зориулалт, ангилал, зарцуулах чөлөөтэйг нэрийнхэн тухай бүр хүргүүлж ажилласан. Мөн дүүргийн сонгуулийн хороодод шаардлагатай зардлын судалгаа, тооцоог тухайлбал, санал авах байрны бодит байдлыг түрээсийн байрны судалгааг дүүргийн сонгуулийн хороодоос авч, нэгтгэн гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд уламжлан, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлж ажилласан тул дээрх дүгнэлттэй санал нийлэхгүй байна.

3. Тайлангийн төслийн зарчлаар дурдсан "Нийслэлийн сонгуулийн хороонд" гэснийг "Нийслэл, дүүргийн сонгуулийн хороонд" гэж өөрчлөх саналтай байна.

Дүүргүүдийн сонгуулийн хороодоос ирүүлсэн тайлангийн санал дүгнэлт, ир хавсаргав.

2

Сонгуулийн санал авах үйл ажиллагааг богино хугацаанд хүн хүч, ажилчдын хүрэлцээ маш муу, дүүргийн сонгуулийн хороод нэг нэгтгэл бодогч, нэг бичиг хэргийн ажилтантай ажилласан байдлыг харгалзан үзнэ үү.

Хавсралт: Хуудастай.

ДАРГА Л.ХОСБАЯР




НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД
Улаанбаатар хот, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170,
Утас: (076) 7010 127-1

НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД

2024.08.14 № 26
Төсөл: 2024.08.09 -ийн № 1134

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн зардалд аудит хийхэд алдаа зөрчил гаргаагүй бөгөөд "Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах" гүйцэтгэлийн аудитын тайланд өгөх саналгүй болно.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ДАРГА Ж.ЛХАГВАСҮРЭН




НАЛАЙХ ДҮҮРГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО
Улаанбаатар хот, 2 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170,
Утас: (076) 7010 127-1

НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД

2024.08.14 № 26
Төсөл: 2024.08.09 -ийн № 1134

Улсын их хурлын 2024 оны сонгуулийн зардалд аудит хийхэд алдаа зөрчил гаргаагүй бөгөөд "Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах" гүйцэтгэлийн аудитын тайланд өгөх саналгүй болно.

НАЛАЙХ ДҮҮРГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ДАРГА Ж.ЛХАГВАСҮРЭН



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

Замдын гудамж 3, 27 дугаар хороо
Баянгол дүүрэг Улаанбаатар хот 16052
Утас (976 11) 36 35 67

2024.08.14 № 01

танай _____ ны № _____ -т

**НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН
ХОРООНД**

УИХ-ын 2024 оны сонгуулийн зардалд аудит хийхэд алдаа зөрчил гараагүй бөгөөд "Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах" гүйцэтгэлийн аудитын тайланд өгөх саналгүй болно


ДАРГА **Б. МӨНГӨНХҮЯГ**

1620016001

**НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН
ХОРООНД**

Тус даргын сонгууль хэргийг өндөрлөх
төгсөж мөн өргөн дийлэлт оролцож байна


ДАРГА **ПЛАТОНОВ**


**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ХОРОО**

Хан-Уул дүүргийн даргын газар
Хан-Уул дүүрэг Улаанбаатар хот 17042
Утас (976) 3777 1505
Эхлэмж нуруудан 10000 khannuul.mn

2024.08.14 № 02/1624

**НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН
ХОРООНД**

Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн үйл ажиллагааны зардалд аудит хийхэд алдаа зөрчил гараагүй бөгөөд "Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах" гүйцэтгэлийн аудитын тайланд өгөх саналгүй болно


ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ **З БУЯАНТ**

1723041487

НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД

Тайлбар дүргүүлэх тусай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн 8 дугаар тойрогт 124 хэсгийн хороо 1,118 хэсгийн хорооны гишүүд 136 даамал, дүүргийн сонгуулийн хороонд 14 албан хаагч нийт 1,266 албан хаагч ажиллаж дүүргийн хэсгээр сонгуулийн нэвчлэл 243.9 мянган иргэдийн 71 хувь нь санал өгсөн байна

Сонгуулийн багтгал амжилт болон санал зургах үйл ажиллагаа дүүргийн хэмжээнд хийрэг зөрчил дутагдалгүй амжилтай

Гэвч сонгуулийн багтгал, даргын үндсэн санхүүжилтийн дүн, гутлааа тодорхойгүй, санхүү, бичиг зэргийн албан хаагчдын оролцоо бага болсон нь нийслэл ачааллыг нэмэгдүүлж хэсгийн хорооны үйл ажиллагаа эрэлцэж, түрээсийн байрсуудын гэрээ болон цахилгааны нөөц үүсгүүрийн дүн тодорхойгүй байдалууд үүсгэсэн нь зарнал үүсгээд нөлөөлсөн

Дээрх байдлаас үүдэн үйл ажиллагааны хэвийн байдлыг хялбар ажиглахыг бүх хэсгийн хороонд үүрэг болгосон дагуу нөөц үүсгүүрийн өөрсдийн боломжорд түлгүүрлэн бэлдүүлж амжилттай бөгөөд санхүүжилтийг санал авах өдөрт түрэн хэмжээг нь тэрэгнүүлж болгох тусламж тусал хийж боломжгүй шалтгааруудыг зардлуулалтыг тооцох боломжгүй байсан

Иймд, дээрх үүрэг шалтгаануудыг дараагийн сонгуульд хэрэглэж үүрэг шалдарталтай талар өргө хэмжээг ажиглах нь зүйтэй байна





Аудитаар илэрсэн алдаа, зөрчил			
№	Дүүрэг нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Хавсралт 1
			Мөнгөн дүн /мянган төгрөг/
1	БГД СХ	Хуваарилсан төсвийг ангилал хооронд зөвшөөрөлгүй шилжүүлсэн.	1,650,000.0
2	БЗД СХ	БЗД-ийн 124 хэсгийн хорооны мотор түрээслэхдээ гэрээ байгуулаагүй, моторт хийсэн шатахууны анхан шатны баримт бүрдэл дутуу.	18,600,000.0
3	БЗД СХ	Болзошгүй зардлыг санал өгөх байрны тохижилтод буюу зориулалт бусаар зарцуулсан.	800,000.0
4	БНД СХ	Болзошгүй зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй ариутгал халдваргүйтгэлд зарцуулсан.	500,000.0
5	БНД СХ	Хуваарилсан төсвийг ангилал хооронд зөвшөөрөлгүй шилжүүлсэн.	190,000.0
6	НД СХ	Мөнгөн талан олгохдоо гарын үсэг дутуу зуруулсан.	2,300,000.0
7	НД СХ	Болзошгүй зардлыг зориулалт бусаар зарцуулсан.	500,000.0
8	СБД СХ	Хуваарилсан зардлыг ангилал хооронд зөвшөөрөлгүй гүйлгэсэн. Зарим зардлыг илүү зарцуулсан.	552,000.0
9	СБД СХ	Гэрээ дүгнэсэн акт байхгүй.	1,700,000.0
10	СБД СХ	Болзошгүй зардлаас принтерийн хор авч зориулалт бусаар зарцуулсан.	552,000.0
11	СБД СХ	Жолоочийн тооцооны хуудас хаанаас хаа хүрэх тодорхойгүй бичээгүй, спидометрийн заалт бичээгүй, баримт нөхөн бүрдүүлсэн	6,420,000.0
12	СХД СХ	Зардлыг ангилал хооронд зөвшөөргүй шилжүүлж зарцуулсан.	1,953,150.0
13	СХД СХ	Жолоочийн тооцооны хуудаст спидометрийн заалт бичээгүй, гарын үсэг зуруулаагүй,	3,050,000.0
14	НСХ	Нийслэлийн сонгуулийн хорооноос дүүргийн сонгуулийн хороодод хуваарилсан зардлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй.	-
Нийт дүн			38,767,150.0